




АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН А/812 ТООТ ЗАХИРАМЖ “ОЛОН НИЙТЭД ЧИГЛЭСЭН САРЫН АЯНЫ” ХҮРЭЭНД ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРААС ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН

Аймгийн Засаг даргын 2024 оны 11 сарын 14 өдрийн А/812 тоот захирамжийн дагуу Хүнс, хөдөө аж ахуйн газрын газрын дарга удирдамж гаргаж, томилогдсон бүрэлдэхүүн удирдамжийн дагуу “Хүүхэд хамгаалал, болзошгүй эрсдэлээс хамгаалах, аюулыг илрүүлэх, арилгах” арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ сургуулийн хүүхдүүдэд Хүнсний аюулгүй байдал, хүнсийг хэрхэн сонгож хэрэглэх талаар мэдээлэл, сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа.



1. Ерөнхий боловсролын 1-5 дугаар сургууль орчны 3 худалдааны газар, нарийн боов, сүү, бууз, баншны 3 цехийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар 2 худалдааны газраас хадгалалтын хугацаа дууссан 149 ширхэг бохь, 9 ширхэг шоколад илэрснийг тухайн газар дээр нь устгуулж, 2 төрлийн хаяг, шошгын зөрчилтэй бүтээгдэхүүнийг лангуун дээрээс татан авхуулсан.





2. Стандартын шаардлага хангаагүй орчинд үйл ажиллагаа явуулсан нарийн боовны 1 цехийн үйл ажиллагааг улсын байцаагчийн актаар зогсоож ажилласан.

3. Ерөнхий боловсролын Говийн ирээдүй сургуулийн 87 сурагч, Хүмүүнлэг сургуулийн 72 сурагч, Мандал сургуулийн 175 сурагч, Эрдмийн далай сургуулийн 182 сурагч, Хүмүүнлэг сургуулийн 72 сурагчдад сургалт зохион байгууллаа.
4. “Сургуулийн орчинд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүн”, “Хүнсний бүтээгдэхүүний хаяг шошгыг хэрхэн унших”, “Хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах сахар, давс, өөх тосны агууламж”, “Хүний өдөрт авах илчлэг, сахар, давс, өөх тосны хэмжээ”, “Худалдааны газруудын хүнсний бүтээгдэхүүн хадгалах горим”-ын талаарх сургалтыг 3-5 дугаар ангитай нийт 4 сургуулийн 516 сурагчид зохион байгуулсан.




5. Сургуулийн орчинд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүнээр зөвлөмж бэлтгэж, байгууллагын веб сайтад байршуулж, иргэдийг мэдээллээр ханган ажилласан.



ТАЙЛАН БИЧСЭН:

ЗАХИРГАА АЖ АХУЙН АЛБАНЫ ДАРГА

Ж.ШИНЭ-УЯНГА



ТАЙЛАН БИЧСЭН:

ЗАХИРГАА АЖ АХУЙН АЛБАНЫ ДАРГА

Ж.ШИНЭ-УЯНГА